50	1.2.2 8	Монгол Улсын түүх судлалыг хөгжүүлж, Монгол Улсыг сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлнэ.	3	Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Монгол бичиг”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол бий биелгээ”, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2008-2012	<p>“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II”-ийг хэрэгжүүлж, олимпиад, Өвгөөдэй Дамдинсүрэн, гавьяат багш Т.Гаваа нарын нэрэмжит Монгол бичгийн олимпиад, “Сайхан бичигтэн-2009” уралдаан, “Хүмүүн бичиг” сонин захиалах хөдөлгөөн өрнүүлж, улсын хэмжээнд захиалгаараа 1-р байр эзэлж, 11 сум, сургууль “Монгол бичгийн төв” байгуулж, 25 ЕБС монгол бичгийн кабинеттэй болж, 64 албан байгууллага хаягаа монгол бичгээр шинэчилсэн. “Гэрийн багш” шалгаруулах, “Монгол бичгийг дэлгэрүүлэгч сурагч”, “Монгол бичигтэн-баг” болзлууд зарлан, 16-49 насны монгол бичиг мэддэг иргэдийн тоо-15257 буюу 37%-д хүрэв. “Аймгийн өсвөрийн уртын дууч, морин хуурчид”-ын 2-р уралдааныг Боржигоны нэрт морин хуурч П. Гомбодорж, “Дууч” хэмээн алдаршсан Баянбараатын нэрт уртын дууч Цэрэн агсны нэрэмжит болгон зохион байгуулж, 8 сумын 26 сурагч амжилттай оролцлоо. Хөгжмийн багш нарт Морин хуур, Уртын дуу, Хөөмийн хичээл заах тухай сургалт явуулж, хичээлийг CD-д хувилан бүх сумдын хөгжмийн багш нарт олгов. Солонгос улсын Кангвонь мужид МТТ-ын уран бүтээлчид хөөмийн төрлөөр оролцов. Жуулчны улирлын үеэр МТТ-ын уран бүтээлчид “Манзушир”, “Женко тур”, “ХIII зуун” зэрэг аялал жуулчлалын газруудад ардын хөгжим, уртын дуу, хөөмий, магтаал, биелгээ, зэрэг төрлүүдээр тоглож байна. МУЗГ-ын 2009 оны 135дугаар тогтоолоор Алтанбулаг сумын “Өнгөтийн цогцолбор”, Дэлгэрхаан сумын “Их хөшөөт” ТСДГ-ын хамгаалалтын бүсийг тогтоов. ХБЦГазар “Өнгөтийн цогцолбор”-ын хашааг шинэчилсэн.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
<b>1.3.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого</b>						
55	1.3.1	Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулна.	2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.	2009-2012	<p>Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын байр бий болгоход анхаарч, Сумдын засаг даргын Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 1 бүтээгдэхүүн болгон дүгнэж байна. Хувийн хэвшлийн байгууллага ААН-тэй ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, тэдэнд хуулийн дагуу урамшуулал олгох гэрээ байгуулан төсөвт тусгагдсан ажил олгогчын урамшууллыг зөв бүрэн ашиглах ажлыг сайжруулан ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд бий болсон болон орон нутаг, иргэдийн санаачилгыг дэмжих, газар тариалан, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэх, бий болсон ажлын байрыг тогтвортой байлгахад аймаг орон нутгаас дэмжлэг үзүүлэн ажилласнаар 2009 онд 2007 шинэ ажлын байр бий болсон.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>

60	1.3.6	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60,0 мянгаас дээш ажлын байр бий болгоно.	2	“Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2012	<p>Өрхийн хөгжлийн хөтөлбөр батлагдан гараагүй байна. “Хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгааны ажлын удирдамж” гарган өрхөд байгаа хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгаа, тоог сум бүрээр тогтоосон. Өрхийн нэг гишүүнийг байнгын ажлын байртай болгох талаар өрхийн төлөвлөгөөг орон нутагтай хамтран боловсрууллаа. Хувийн болон өрхийн АА эрхлэх иргэдийн ур чадвар мэдлэгийг дээшлүүлэх Ногоо тариалах сургалтыг 61, сүү цагаан идээ боловсруулах сургалтыг 25, аж ахуй эрхлэх сургалтыг 88, мэргэжил олгох сургалтанд 64 иргэнийг хамруулан зохион байгуулж, 70 хувийг байнгын ажлын байраар хангасан. 2009 оны жилийн эцсийн байдлаар 2088 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлан, иргэдийг зээл, төсөл хөтөлбөрт хамруулсанаар 2007 ажлын байр шинээр бий болгон E-job мэдээллийн санд орууллаа.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
61	1.3.7	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрыг түшиглэсэн түргэвчилсэн сургалтаар мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжиж, мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулна.	1	Эрэлтэд тулгуурласан “Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ.	2009-2012	<p>27 суманд сургалтын эрэлтийн судалгааг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд явуулан судалгаа, эрэлтэнд суурилан сургалтыг явуулж байна.</p> <p>2009 онд мэргэжил олгох 8 сургалтын байгуулагатай 16 төрлийн мэргэжлээр аймгийн ажил, мэргэжилгүй иргэдийг сургах гэрээ байгуулав. Мэргэжил олгох сургалтыг иргэд, орон нутгийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, байршлын онцлогийг харгалзан Улаанбаатар хотод явуулж байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 379 иргэнийг мэргэжил сургалтанд хамруулан Мэргэжил эзэмшсэн чадамжийн гэрчилгээ олгов. Аймагт жижиг аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих “Бизнесийн хөгжлийг дэмжих төв” байгуулж 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. БХТөв 21 сумын 453 гаруй иргэдэд сургалт явууллаа.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>

69	1.3.15	Өрх бүрээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн нэгээс доошгүй хүнийг мэргэжил эзэмшүүлж, ажилтай болгоно.	1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог гурав дахин нэмэгдүүлнэ.	2009-2012	2007-2008 оны хичээлийн жилд Баянчандмань, Заамар, Зуунмод, Эрдэнэ сумын МСҮТөвд нийт 37 мэргэжлээр 1243 суралцагч суралцаж, 2008-2009 оны хичээлийн жилд Баянчандмань, Заамар, Зуунмод, Эрдэнэ сумын МСҮТөвд нийт 37 мэргэжлээр 1503 суралцагч суралцаж, суралцагчдын тоог 260-аар буюу хүүхдээр нэмэгдсэн. 2009-2010 оны хичээлийн жилд 35 мэргэжлээр 1817 суралцаж 314 хүүхдээр буюу 1.2 дахин нэмэгдэв. <b>Хэрэгжилт 30%</b>
----	--------	---	---	--	-----------	---

#### 1.4. Нийгмийн хамгааллын бодлого

75	1.4.1	Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрөл, хэлбэрийг оновчтой болгоно.	1	Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна.	2009-2012	Шинээр 27 суманд Хөдөлмөр халамжийн мэргэжилтнийг орон тоогоор ажиллуулж байна. Сумын хөдөлмөр халамжийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан Төрийн албаны аймгийн салбар зөвлөлийн даргаар батлуулан мөрдөж байна. Аймаг сумын хөдөлмөр халамжийн мэргэжилтнүүдийг “Нийгмийн халамжийн тухай” багц хуулиуд, журам, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх, практик ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, Халамжийн үйлчилгээний менежер программыг нэвтрүүлэх, сүлжээний орчинд ажиллах 2 удаагийн сургалтанд хамруулан мэдлэг чадвар олгосон. “Нийгмийн ажилтаны холбоо”-той хамтран орон нутгийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулан сертификат олгож, ажлын туршлага солилцон бүсийн үзүүлэх сургуулийг Баяндэлгэр, Угтаалцайдам Өндөрширээт, Батсүмбэр суманд зохион байгуулав. <b>Хэрэгжилт 30%</b>
----	-------	---	---	--	-----------	--

80	1.4.6	Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулж, түүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах бодлого баримтална.	1	Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна.	2009-2012	Шинэ бүтцийг хэрэгжүүлэн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажил үүргийг оновчтой болгон Хяналт шинжилгээ үнэлгээ, хүн ам гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарыг шинээр бий болгон ажиллаж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, олон нийтийн оролцоо хяналтыг сайжруулахын тулд 27 сумын “Амьжиргааг дэмжих зөвлөл”-ийн гишүүдийг чадваржуулах сургалт-зөвлөгөөнийг 4 бүс болгон зохион байгууллаа. Хөдөлмөр халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд сум орон нутгаас анхаарах ажил үйлчилгээг гарган “Сумын төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх хөдөлмөр халамжийн үйлчилгээ” үзүүлэх сургуулийг 27 сумыг хамруулан хийж, Хөдөлмөр халамжийн нээлттэй өдөрлөгийг 5 удаа зохион байгууллаа. <b>Хэрэгжилт 50%</b>
85	1.4.11	Амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгож, ядуурлын зураглал гарган нийгмийн хамгааллын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай болно.	2	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	2009-2012	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдаж гараагүй байна. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НХХЯамтай хамтран амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгож байгаа бөгөөд манай аймгийн Эрдэнэ, Зуунмод сумын 45 өрхөөс судалгаа авч туршсан. <b>Хугацаа болоогүй</b>
86	1.4.12	<i>Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжих “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг</i>	1	Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачилгад тулгуурлан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	2009-2010	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” батлагдаж гараагүй байна. ХЭДТХууль, Нийгмийн Халамжийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа тул улсын “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-батлагдаагүй байгаа бөгөөд аймгийн өрхийн хөгжлийн хөтөлбөр төслөөр боловсрогдож байна. <b>Хугацаа болоогүй</b>

	<p><i>боловсруулан хэрэгжүүлэх замаар 50000-аас доошгүй ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.</i></p>	2	<p>“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна.</p>	2009-2012	<p>Аймгийн хэмжээнд 477 өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилт дэвшүүлэн аймгийн Засаг даргын 2009 оны 79 тоот захирамжаар сум, баг, өрхийн түвшинд хийх ажлын удирдамжийг гарган ажиллаж байна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлалын дагуу 300 гаруй иргэнд сургалт зөвлөгөө өгч, 450 өрхийг хөгжлийн төлөвлөгөөтэй болгон ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах 477 өрхийн 88.9 хувь буюу 424 нь өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй болж, амьжиргаагаа дээшлүүлэх талаар хийх ажлаа төлөвлөн ажиллаж, 18 сум ядуурлаас гаргах өрхүүдээ сумын удирдах албан тушаалтан, албан байгууллагад хариуцуулан ажиллаж байна. Сум бүрийн онцлогийг харгалзан боломжтой гэж үзсэн үзүүлтүүдээр амьжиргааны түвшинг тодорхойлов. Дээрх өрхүүдийн 75% нь буюу 357 өрхийн амьжиргаа дээшилсэн дүнтэй байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
		3	<p>Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж, хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна.</p>	2009-2012	<p>Засгийн газраас 2009 онд аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах өрхийн тоог 477 болгон шинэчлэн тогтоосон дагуу аймгийн Засаг даргын 79 тоот захирамж гарган “ Өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх ажлын удирдамж”, ядуурлаас гаргах өрхийн тоог сум бүрээр тогтоон хүргүүлсэн. Өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд авах арга хэмжээний талаар 27 сумын АДЗөвлөлийн 143 гишүүдэд сургалт явууллаа. Ядуурлаас гаргах өрхүүдээс аж ахуй эрхлэх сургалтанд-253 хүн, мэргэжил олгох сургалтанд-24 хүн, төсөл хөтөлбөрт-169 иргэнийг хамруулан 63 иргэнд тэтгэвэр тэтгэмж шинээр тогтоосон байна. Ядуурлаас гаргах өрхөөс 185 хүнийг ажилд зуучилан оруулж, 258 өрх өөр ногоо тариулан 71 иргэнд 723, сая төгрөгийн зээл олгосон байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
		4	<p>Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.</p>	2009-2012	<p>Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг чадваржуулах сургалт-зөвлөгөөнийг 4 бүсэд зохион байгуулан 143 хүнийг хамруулж сумдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар хийж байгаа ажлын туршлагыг харилцан солилцох, зөвлөлийн гишүүдийг чадваржуулсан. Орон нутгийн ТББ, ядуу иргэдийн бүлэг болон хөдөлмөр эрхлэн орлогоо нэмэгдүүлэх санал санаачилга дэмжин ОНОТХҮ Хөтөлбөрийн хүрээнд сумын 18 хөдөлмөрийн бүлэгт 18 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 байгууллагад 6.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн..</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>

89	1.4.15	Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын дадал олгох, аливаа хорт, муу зуршлаас ангид байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгох чиглэлээр гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжинэ.	1	"Хүн байхын учир" аяны өргөжүүлж, хүүхэд, өсвөр үеийхний "Гэр бүлдээ үүнийг хүснэ", "Миний паспорт", "Миний нэрийн хуудас" зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжинэ.	2009-2012	"Миний нэрийн хуудас" аяны хүрээнд "Миний оролцоо" үйл ажиллагаа явуулж, төлөвлөгөө гөргөн сум бүрд хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн албатай хамтран 9 сумын Өсвөрийн сэргийлэгчдийн бүлгийн 30 гаруй хүүхэд оролцуулсан сургалт-цугларалт зохтон байгуулав. "Миний эрүүл мэнд" үйл ажиллагааны хүрээнд Хүүхэд өсвөр үеийнхэнд үйлчилгээ үзүүлэх "Золбоо" төв нээн ажиллуулж НҮЭМ, бэлгийн боловсролын чиглэлээр 20 үе тэнгийн сургагч бэлтгэв. Сургагч нараар дамжуулан хүүхдүүдэд НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт хийж байна. Сургалт сурталчилгаанд нийт 475 хүүхэд хамрагдсан. "Миний хөгжил" үйл ажиллагааны хүрээнд өөрийгөө хөгжүүлэх дугуйлан секцэнд хамрагдан хичээллэж байна. "Мэдээлэл харилцаа" үйл ажиллагааны хүрээнд аймгийн ТБС телевизийн дэргэд өсвөрийн 3 сурвалжлагч бэлтгэгдэн 7 хоногт 20 минутын хугацаатайгаар хүүхдийн нэвтрүүлэг бэлтгэн хөтөлж байна <b>Хэрэгжилт 30%</b>
			2	Хүүхэд амралт, чөлөөт цагаа өнгөрөөж, мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийж, хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч энэрэнгүй, нийгмийн идэвхтэй иргэн болгож төлөвшүүлэх талаар эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллана.	2009-2012	Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар 8 сумын 519 хүүхдээс судалгаа авч, дүнг үндэслэн сургалт зохион байгуулсан. БСГ, ХТХэлтэс хамтран "Аймгийн эцэг эхийн анхдугаар зөвлөгөөн" зохион байгуулж, Зуунмод сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, багш, эцэг эхийн төлөөлөл, албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга, эцэг эхийн зөвлөлийн дарга бүхий 100 хүн оролцсон. Өндөрширээт, Лүн, Баянхангай сумдын ЕБС-ийн 75 багш, эцэг эхчүүдэд энэ зөвлөгөөний талаар уулзалт хийж сурталчлав. Дэлхийн зөн ОУБ-ын Төв ОНХХ-тэй хамтран ирээдүйн чадварлаг удирдагчдыг бэлтгэх, өсвөр үе залуучуудыг мэдээллээр ханган чадваржуулах, тэдний ярих, манлайлах чадварыг хөгжүүлэх зорилготой "Манлайлагч ТВ хөтөлбөр"-ийг Зуунмод сумын 4-н сургуулийн 47 хүүхдийн дунд зарлан 20 хүүхдийг шалгаруулж, Зуунмод сумын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, багаар хэрхэн ажиллах, мэргэжлээ хэрхэн сонгох сэдвүүдээр сургалт, аялал, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэргийг 4 сарын хугацаанд зохион байгуулж дүгнэв. <b>Хэрэгжилт 30%</b>

			3	Хүүхэд, өсвөр үеийхний дунд эрүүл амьдралын дадал хэвшүүлэх, зохистой хооллолтыг эрхэмлэх, хорт зуршлаас татгалзах мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.	2009-2012	Зуунмод сумын ЗДТГазар, Хүүхдийн элч, Эрүүл мэндийн газартай хамтран Хүмүүн цогцолбор сургууль, 4, 5-р сургууль, МСҮТөвийн ХӨУБ, хүүхдийн оролцооны 18 байгууллагын идэвхтэн сонгуультан 54 сурагчийг хамруулан ХЭК, ХЭХУуль, хүүхдийн оролцоо, архи тамхины хор уршиг, ДОХ, бэлгийн замын халдварт өвчин сэдвүүдээр сургалт явуулав. Аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн алба, Хүүхдийн Төлөө Хэлтэс хамтран 9 сумын 3 гаруй Өсвөрийн сэргийлэгчдийг хамруулан сургалт-цугларалтыг зохион байгуулав. Цагдаагийн Ерөнхий Газар, Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллага хамтран Дархан хотын “Зулзага” зусланд зохион байгуулсан Төвийн бүсийн өсвөрийн сэргийлэгчдийн чуулга уулзалтад аймгийн Өсвөрийн сэргийлэгчдийн “Шонхор” бүлгийн 10 хүүхэд хүүхдийг Хүүхдийн байцаагчийн хамт оролцуулав.
--	--	--	---	---	-----------	---

**Хэрэгжилт 30%**

**1.5. Хүн амын бодлого**

93	1.5.2	Эцэг, эх нь хүүхдээ эрүүл өсгөн бойжуулж, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчин бүрдүүлэхийг дэмжинэ.	2	“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлана.	2010	
----	-------	---	---	---	------	--

**Хугацаа болоогүй**

97	1.5.6	Ахмад настны эрүүл мэндийг сайжруулахад зориулан эмнэлэг, сувиллын газар, ахмадын ордон байгуулна.	3	Ахмадууд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх, чанартай насжилтыг дэмжих зорилгоор аймаг, дүүрэг бүрт орон нутгийн нөөц хөрөнгө, боллоцгоог ашиглан ахмадын ордон байгуулж ашиглалтад оруулна.	2010-2011	Зуунмод суманд Ахмадын өргөө, зарим сумдад Ахмадын танхим байгуулсан. Аймгийн нэгдсэн эмнэлэг 2009 оноос эхлэн ахмадын Нөхөн сэргээх өдрийн эмчилгээнд Зуунмод сумын 6 багийн 120 ахмад настанг хамруулсан. 2009 оны жилийн эцсийн байдлаар бүх суманд Ахмадын өрөө, танхим болон эмнэлэгт Бие бялдар-чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжөөр ахмад настуудад үйлчилж байна. Бүх суманд Ахмадын Биеийн тамир спортын болон чийрэгжүүлэлтийн хамтлаг, клубүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллуулдаг.
----	-------	--	---	---	-----------	--

**Хэрэгжилт 30%**

101	1.5.10	Хүүхдийн талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодол, хүүхдийн бодитой оролцоог дэмжинэ.	1	Хүүхэд, тэдний өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдний санал хүсэлтийг шийдвэртээ тусгаж ажиллах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангаж ажиллана.	2009-2012	<p>Аймгийн ХТХэлтсээс 14 сумын 850 хүүхдэд “Хүүхдийн оролцоо”-ы тухай ойлголт, оролцооны ач холбогдол, оролцооны хэлбэр, орчны талаар сургалт явуулж, ХӨУБ-ыг шинээр нэмэгдүүлж ажиллахад, үйл ажиллагааныхаа талаар анхаарах, тэднийг нийгэмшүүлэх, өөрийнхөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд арга зүйн зөвлөмж өгч ажиллав. Аймгийн хэмжээнд ХӨУБ-ын нийт тоо139, ХӨУБ-д хамрагддаг хүүхдийн нийт тоог 5837 хүргэж ажилласан. Сумдад ажиллах үеэр “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулж, “Надад хэлэх үг байна” нээлттэй самбар ажиллуулсан. Аймгийн хэмжээнд 27 сум Хүүхдийн Төлөө Зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүндээ тус бүр 1-2 хүүхдийн төлөөлөл оролцуулан, ажлын төлөвлөгөөндөө хүүхдүүдийн саналыг тусган ажиллав.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
<b>ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ</b>						
<b>2.1. Макро эдийн засаг санхүүгийн бодлого</b>						



105	2.1.1	ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг жилд 12 хувиас доошгүй түвшинд хүргэн, эдийн засгийн хурдацтай хөгжлийн нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ.	2009-2012	<p>Эдийн засгийн өсөлтийг дэмжих, салбарын зохистой бүтцийг бий болгоход ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг жилд 12 хувиас доошгүй түвшинд хүргэх зорилтыг Төв аймгийн хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн. 2008 онд ДНБ-ий үйлдвэрлэл 140.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 50,5 хувиар өсч, нэг хүнд 1631.1 мянган төгрөг болсон. 2009 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ДНБ-ий үйлдвэрлэл 172.7 тэрбумд хүрч өмнөх оныхоос 22 хувиар өсөхөөр тооцогдож байна.</p> <p>2008 онд Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 72.1 хувийг ХАА-н салбарын үйлдвэрлэл, 3.7 хувийг аж үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл, 24.2%-ийг үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн эзэлж байна. Эдийн засгийн өсөлтийг сайжруулах зорилгоор “Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлого”-ыг баталж, ажлын байр нэмэгдүүлэх ЖДҮ-ийг дэмжих зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих сан”, сумдад “Өрхийн үйлдвэрлэлийн дэмжих сан”-г тус тус байгуулан зээл олголтыг хийсэн. “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 164 иргэд, аж ахуйн нэгжид 1093.8 сая төгрөгийн зээл олгосон ба “Өрхйн үйлдвэрлэлийн дэмжих сан”-чиглэлээр нийт 500 сая төгрөгийн эх үүсвэр сумдад хуваарилагдан зээл олголтын ажлууд хийгдээд байна. 2009 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллага явуулж буй банкуудын нийт олгосон зээлийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг ба өмнөх онтой харьцуулахад олгосон зээлийн хэмжээ 36.3%-иар өссөн байна. Үүнээс жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор нийт 2223 иргэн ААН-д 4 тэрбум орчим төгрөгийн зээл олгоод байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 50%</b></p>
-----	-------	--	---	--	-----------	---

106	2.1.2	Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг бататгах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг	1	Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна.	2009-2010	<p>Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр, Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр бодлого, хөтөлбөртэй уялдуулан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж мөрдөн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тухайн жилд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлттэй байхаар боловсруулан улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж ирсэн. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг бүс нутгийн болон аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан өмнөх жилүүдэд хүрсэн түвшин, 2010 онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэйгээр төсвийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж батлуулав.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
-----	-------	--	---	--	-----------	--

		хэрэгжүүлнэ.	2	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрэх түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулна.	2009-2010	<p>Аймгийн хэмжээнд нийт хөдөлмөрийн чадвартай 57660 хүн амын 7527 буюу нийт хөдөлмөрийн чадвартай хүн амын 13.1 хувь нь хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн зах зээлд бүртгэлтэй хүн ам эзэлж байна. Ажилгүйдлийг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын хөрөнгө оруулалттай “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”, сумдад “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гуудыг байгуулан шинээр ажлын байр бий болгох, үйл ажиллагаа өргөтгөхөд нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн дэд комиссын шийдвэрээр нийт 27 сумын 164 иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагааны 21 чиглэлээр 1093.8 сая төгрөгийн зээл суманд олгосон. Мөн 27 суманд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор нийт 540.0 сая төгрөгний эх үүсвэрийг хуваарилан зээл олголт тус тус хийгдээд байна.</p> <p>Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ажлын байрыг хадгалах талаар бодлого баримтлан ажилласан бөгөөд 2009 онд нийт 1900 иргэнийг байнгын ажлын байраар, 750 иргэнийг түр ажлын байраар хангав. Жижиг аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжиж шинээр ажлын байр нэмэгдүүлэх хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэгч, ажилгүй нийт 164 иргэн, аж ахуйн нэгжид 157 сая төгрөгний “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас шинээр ажлын байр бий болгох төслийн зээлийг олгоод байна.</p> <p>Мөн ажлын байрыг олноор бий болгох үйлдвэрүүдийг дэмжин ажиллаж байна. Үүнд Жаргалант суманд 50-60 хүнийг ажлын байраар ханган “ХААН-ЕМБҮҮ” ХХК-ын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсэн.</p> <p>Сэргэлэн сумын нутагт шинээр 200 хүний ажлын байр бий болгох БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Улаан цементийн үйлдвэр, мах махан бүтээглэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах эхлэлийг тавиад байна.</p>
--	--	--------------	---	---	-----------	--

**Хэрэгжилт 30%**

			6	Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв хотуудын зорилтот хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ.	2009-2012	2009 онд аймгийн хэмжээнд нийт 9855,1 сая төгрөгийн ажил хийгдлээ. Улсын хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт халдвартын эмнэлгийн барилга-400.0, Жаргалант сумын хүн эмнэлгийн барилгын засвар-22.0, нэгдсэн эмнэлгийн гаражийн засвар-20.0, нэгдсэн эмнэлгийг цахилгааны 2 дахь эх үүсвэрээр хангах ажил-22.0, Зуунмод хотын урлаг спортын цогцолбор-1100, Боловсролын салбарт Эрдэнэ сумын МСС-ийн дотуур байр-472.7, Батсүмбэр сумын сургуулийн өргөтгөл-99.2, Батсүмбэр сумын 100 хүүхдийн цэцэрлэг-361.4, БСГ-ын контор-163.2, Заамар сумын соёлын төв-223.5, Баян сумын соёлын төв-75.0, Алтанбулаг сумын соёлын төв-77.4, Дэлхийн банкны төслөөр Баянжаргалан, Өндөрширээт сумын дотуур байрны засварын ажил хийгдэж ашиглалтанд орлоо. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Эрдэнэсант сумын цэцэрлэгийн өргөтгөлийн ажил, Цээл сумын цэцэрлэгийн барилгын засвар, Аргалант сумын мах боловсруулах үйлдвэр шинээр баригдаж, аймгийн хэмжээнд 74 худаг шинээр гаргах, засварлах, шинэээр барих ажил хийгдлээ. <b>Хэрэгжилт 30%</b>
113	2.1.9	Эдийн засгийн бүтцийг сайжруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх бодлого баримтлана.	2	Дэд бүтэц хөгжсөн бүсийн тулгуур төв-хот, аймгийн төвүүдэд аж үйлдвэрийн парк байгуулах ажлыг хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.	2009-2012	Зуунмод сумын үйлдвэр технологийн холимог парк байгуулах эдийн засгийн тооцоо, мастер төлөвлөгөө хийхэд хамтран ажиллах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжаар байгуулан холбогдох судалгаа, тооцоогоор хангаж ажиллалаа. Төслийн баг Зуунмод сумын үйлдвэрлэл технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХТ-ийн хурлаар батлуулж холбогдох яаманд хүргүүлээд байна. ҮТП 3 үе шаттай хэрэгжих бөгөөд 1-р үе шат буюу 2009-2011 төслийн бэлтгэл хангагдана. 2-р үе шатанд 2012-2015 онд эхний үйлдвэрүүд баригдана. 3-р үе шатанд 2016-2021 онд үйлдвэрүүд эцэслэн дуусна. Энэ төслийн хүрээнд 6 чиглэлийн 15 үйдвэр баригдана. Үүнд: Мах болосруулах үйлдвэр, Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр,Талх, нарийн боовны үйлдвэр, 120,0 мянган ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлэх сүлжмэлийн үйлдвэр, Өндөр технологийн үйлдвэр, Барилгын материалын үйлдвэр, Аялал жуулчлалын төв, Мэдээлэл технологийн парк, Инкубатор парк, Ложистик агуулахын аж ахуй Одоогоор ҮТП-ийн хэсэгчилсэн төлөвлөлт хийгдэж байна.. Энэ урт хугацааны хөрөнгө мөнгө ихээр шаардсан ажил бөгөөд эхний ээлжинд Чехийн хөхөнгө оруулалттай мах боловсруулах үйлдвэр баригдаж ашиглалтын өмнөх захиргааг байгуулан, тоног төхөөрөмж Чехээс нийлүүлэгдэж ирээд байна. Сэргэлэн суманд жилд 1 сая тг цемент үйлдвэрлэх хүчин чадалтай Цементийн үйлдвэр баригдан барилгын ажлын явц 70%, 2010 онд ашиглалтанд орох бөгөөд 280 хүн ажлын байраар хангагдана. <b>Хэрэгжилт 30%</b>

114	2.1.10	Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ.	1	“Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги”-ийг батлуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.	2009-2010	Стратеги батлагдаж гараагүй  <b>Хугацаа болоогүй</b>
131	2.1.27	Шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг нийгмийн сэтгэл зүйд төлөвшүүлж, зах зээлийн өрсөлдөөний орчныг бүрдүүлнэ.	3	Шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2010	Шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хөтөлбөр 2009 оны 12-р сард батлагдсан бөгөөд уг хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх ажлын байгуулагдаж, аймгийн Төлөвлөгөө гарган баталж хэрэгжилтийг зохион байгуулж байна. <b>Хугацаа болоогүй</b>
			4	Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, үндэсний болон олон улсын хэмжээний хурал, семинар зохион байгуулна.	2009-2012	Засгийн газрын түвшинд зохион байгуулагдаагүй байна. 2005 оноос эхлэн манай аймагт “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах ажил тогтмолжоод байна. 2009 онд зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд 350 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн 672 нэрийн бүтээгдэхүүн оролцсон дүнтэй байна. Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 2 жилд нэг удаа уламжлал болон зохион байгуулагддаг ТОП таван аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах ажлыг энэ онд зохион байгуулав. Аймгийн хэмжээний шиллдэг бизнес эрхлэгч, бизнесийг дэмжигч байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг “Интерперенер наадам”-ыг жил бүр зохион байгуулж хэвшээд байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газартай хамтран Зуунмод хотод Өдөрлөг зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөтөлбөр сурталчлав. <b>Хугацаа болоогүй</b>

132	2.1.28	<p>Үндэсний бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, хэрэглэгчийг чанартай, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг эрс сайжруулна.</p>	4	<p>Бүсийн болон аймгийн төвд сорилт, хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй орчны чанар, аюулгүй байдлын сорилт, шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилтын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно.</p>	<p>2009-2010</p> <p>Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн сорилтын болон хэмжилзүйн лаборатори нь 2008 онд “сорилтын болон калибровкийн лаборатори чадавхид тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IES 17025: 2007 стандартын шаардлагыг хангаж 2 жилийн хугацаагаар итгэмжлэгдэн үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аймгийн төвд нэгдсэн лабортори байгуулах асуудлыг аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулсан.</p> <p>2009 онд сорилтын лаборатори нь хүнсний аюулгүй байдлыг хагуулах, хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүнээр хангах зорилгоор давхардсан тоогоор 67 байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 151 нэр төрлийн бүтээгдэхүүнд 843 үзүүлэлтээр химийн сорилт шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний үзүүлэлтээр шаардлага хангахгүй гарсан 7 бүтээгдэхүүнийг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэж холбогдох арга хэмжээ авахуулсан.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 30%</b></p>
-----	--------	--	---	--	--

